



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 08 сарын 11 өдөр

Дугаар 263

Улаанбаатар хот

Г

Алсын дуудлага, явуулын эмнэлгийн  
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Эрүүл чийрэг Монгол хүн” бүлгийн 177 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 318 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний түргэн тусlamжийн сүлжээ хөтөлбөр”, “Эмнэлгийн яаралтай тусlamжийн шинэчлэл” стратегийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Алсын түргэн тусlamжийн дуудлагын шуурхай байдлыг хангах, чирэгдлийг бууруулах зорилгоор 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс алсын түргэн тусlamжийн дуудлагын үйлчилгээг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс тушаалын 2 дугаар хавсралтад заасан байгууллагуудын яаралтай тусlamжийн тасгийн үйл ажиллагаанд шилжүүлсүгэй.
2. Алсын түргэн тусlamжийн дуудлагын үйлчилгээ үзүүлэх журмыг нэгдүгээр, алсын дуудлагын үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын хуваарийг хоёрдугаар, явуулын эмнэлгийн үйлчилгээний хуваарийг гуравдугаар, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс шилжих хөрөнгийн жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Алсын түргэн тусlamжийн дуудлагын үйлчилгээг шилжүүлсэнтэй холбогдуулан алсын дуудлагын машин, жолооч, бага эмчийг төсвийн хамт, явуулын эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх тоног төхөөрөмж бүхий 3 машиныг уг тушаалын 2,3 дугаар хавсралтад заасан эмнэлэг, төвүүд хүлээн авч, иргэдэд үзүүлэх яаралтай болон явуулын эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг хангаж ажиллахыг холбогдох төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлгийн дарга нарт даалгасугай.
4. Алсын түргэн тусlamж, явуулын эмнэлгийн тусlamж, үйлчилгээний холбогдох статистик мэдээ, мэдээлэл, тайланг хагас, бүтэн жилээр гаргах, төрөлжсөн мэргэжлийн олон дуудлага зэрэг ирсэн үед зохицуулалт, мэргэжил аргазүйгээр хангах, алсын дуудлагад телемедицинээр зөвлөгөө өгөх үйлчилгээг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат –Эрдэнэ) - д, алсын түргэн тусlamжийн батлагдсан чиг үргээс бусад чиглэлээр ирүүлсэн дуудлагад зохих шатны эрүүл мэндийн байгууллагын эмч,


081873

мэргэжилтнүүдийг татан оролцуулж ажиллахыг хавсралтанд заагдсан эмнэлгийн дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

5. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс энэ тушаалын 2, 3 дугаар хавсралтад заасан төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд шилжих төсвийг хянаж, шилжүүлэх, эд хөрөнгийг балансаас балансад холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэх, байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд авах, цаашид алсын дуудлага, явуулын эмнэлгийн үйлчилгээнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган батлуулж ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (Д.Төмөрбаатар), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат эрдэнэ), холбогдох төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа) -д даалгасугай.

7. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 440 дүгээр тушаалын хавсралтаар баталсан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүтэц, чиг үүргээс "аймаг орон нутагт нарийн мэргэжлийн алсын дуудлагын үйлчилгээ үзүүлэх"- гэснийг болон Эрүүл мэндийн сайдын 2005 оны 25 дугаар тушаалын 2,4,5 дугаар заалт, 2009 оны 144 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Эрүүл мэндийн сайдын 2014 оны  
08... сарын 11... өдрийн 163 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт

АЛСЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГЫН  
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг зүйл**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн алсын дуудлагын дагуу төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв мэргэжлийн чиглэлээр яаралтай тусlamжийн үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Алсын түргэн тусlamжийн дуудлага “цаашид алсын дуудлага” гэх” - ын үйл ажиллагаанд Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 2012 оны 150, 151-р тогтоол, энэхүү журам болон холбогдох бусад хууль эрхийн актыг дагаж мөрднө.
- 1.3. Алсын дуудлагын үйл ажиллагаа нь алсын яаралтай тuslamжийн дуудлага дуудах өвчин, эмгэгийн жагсаалт (тус журмын 1 дүгээр хавсралт)-ын дагуу өвчний онош тавигдсан үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, хүндрэлээс сэргийлэхэд чиглэсэн төрөлжсөн мэргэжлийн тuslamжийг үзүүлэхэд чиглэгдэнэ.
- 1.4. Алсын дуудлага дуудах өвчин, эмгэгийн жагсаалтад заагдаагүй оноштой үйлчлүүлэгчид утас болон телемедицины сүлжээг ашиглан зөвлөгөө авна.
- 1.5. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн алсын дуудлагыг уг тушаалын хоёрдугаар хавсралтад заагдсан алсын дуудлагыг хүлээн авч, зохицуулах чиг үүрэг бүхий төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгээс ирүүлсэн дуудлагыг аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв тус тус хүлээн авч зохицуулна.

**Хоёр. Алсын дуудлага хүлээн авч, зохицуулагч байгууллагын чиг үүрэг**

- 2.1 Улсын төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал нь алсын түргэн тuslamжийн дуудлагаар явах эмч, мэргэжилтний хуваарийг сар бүр батлан мөрдүүлж дуудлагыг зохицуулан ажиллана.
- 2.2 Алсын түргэн тuslamжийн дуудлаганд явах дуудлагын эмч, мэргэжлийн багийг /цаашид “баг” гэх/ 2 цагийн дотор бэлэн болгож, шуурхай зохион байгуулах үүргийг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга хариуцна.
- 2.3 Шаардлагатай тохиолдолд нэхэн томилгоо болон нэмэлтээр алсын дуудлаганд явах эмч мэргэжилтнийг томилох, шаардлагатай эм тариа, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах ажлыг эмчилгээ эрхэлсэн орлогч дарга зохион байгуулна.
- 2.4 Улсын төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь орон нутгийн эмч мэргэжилтнүүдийг яаралтай тuslamжийн чиглэлээр мэргэшүүлэх, дадлагажуулах ажлыг жил бүр зохион байгуулж, лавлагаа төвийн үүргийг үндэсний түвшинд гүйцэтгэж, арга зүйгээр хангаж ажиллана.

- 4
- 2.5 Алсын дуудлага гүйцэтгэж ирсэн эмч, мэргэжилтнийг дуудлагаас ирсэн өдөр ажлаас чөлөөлж, амралт олгох асуудлыг зохицуулна. Алсын дуудлагыг хүлээн авч дуудлага зохицуулагч ажилтан, жолоочийг 24 цагаар ажиллуулна.
- 2.6 Алсын дуудлагын мэдээллийг дуудлага зохицуулагч ажилтан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 450 дугаар тушаалаар баталсан “Алсын дуудлагын хуудас”-ын дагуу тэмдэглэн, холбогдох материал (өвчний түүх, лабораторийн болон багажийн шинжилгээний хариу, эмч нарын хамтарсан зөвлөгөөний шийдвэрийн баталгаажсан хувилбар, зэрэг)-ыг факс, и-мэйл-ээр хүлээн авна.
- 2.7 Дуудлага зохицуулагч ажилтан нь алсын түргэн тусlamжийн дуудлагын талаарх мэдээллийг холбогдох албан тушаалтанд 15 минутын дотор мэдэгдэж, төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтнийг томилон гаргах, телемедицинээр эсвэл утсаар (телемедицины сүлжээнд холбогдоогүй байгууллагад) эмнэлзүйн зөвлөгөө өгөх эсэх асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 2.8 Телемедицинээр өгөх эмнэлзүйн зөвлөгөөг “Телемедицины үндэсний сүлжээний байгууллагуудын ажиллах журам”-ын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулна.
- 2.9 Дуудлаганд явах эмч, багийг орон нутаг болон онгоц, галт тэрэгний буудалд хүргэх, тосож авах, телемедицин болон утсаар зөвлөгөө өгөх эмч, мэргэжилтнийг авах, хүргэх асуудлыг дуудлага зохицуулагч ажилтан зохион байгуулна.
- 2.10 Дуудлага зохицуулагч ажилтан нь жолоочид эрүүл мэндийн үзлэг хийж, хяналтын хуудсыг (тус журмын 2 дугаар хавсралт) бөглөсний дараа ажилд гаргах асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.11 Алсын дуудлагын тээврийн хэрэгсэл нь үйлчлүүлэгчийг тусгай мэргэжлийн төв, эмнэлэг рүү тээвэрлэх явцад яаралтай тусlamж үзүүлэх, эрчимт эмчилгээ хийх боломжтой багаж, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.
- 2.12 Алсын дуудлагын тээврийн хэрэгслийн дуут болон гэрлэн дохио ашиглах зөвшөөрлийг 3 жил тутамд сунгадаг журмыг аймаг, нийслэлийн ЗЦГ-тай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.13 Дуудлага зохицуулагч ажилтан нь дуудлагын болон томилолтын хуудсыг дугаарлах, бүртгэх, батлуулах, онгоц, галт тэрэгний тийз худалдан авах, олгох, санхүүгийн тооцоо хийх ажлыг хариуцна.
- 2.14 Дуудлага дуудсан байгууллага болон дуудлага зохицуулагч нар нь дуудлаганд яваа багтай холбоотой ажиллаж, байршилын мэдээллийг авах, 2 талаас замын бартаа, цаг агаарын байдлыг мэдээлж ажиллана.
- 2.15 Дуудлага зохицуулагч ажилтан нь дуудлагын болон томилолтын хуудас, жолооч, тээврийн хэрэгслийн үзлэгийн хуудсын бичилтэд хяналт тавьж, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, орон нутагт нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч даргад танилцуулна.
- 2.16 Холбогдох төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, орон нутгийн нэгдсэн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга нар алсын дуудлагын сарын тайланг дараа сарын эхний өдөр цаасаар болон файлаар Эрүүл мэндийн хөгжлийн төвд өгнө.
- 2.17 Дуудлага зохицуулагч ажилтан нь нийтээр амрах, баяр ёслолын өдрүүдэд Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн хөгжлийн төв, аймгийн Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрт алсын дуудлагын шуурхай мэдээллийг хүргэнэ.
- 2.18 Алсын дуудлагын хуваарыт гарсан өөрчлөлтийг холбогдох байгууллагад мэдэгдэх үүргийг дуудлага зохицуулагч хариуцна.

- 2.19 Алсын дуудлаганд явах эмч, мэргэжилтэнд өвлийн улиралд нэмэлт дулаан хувцас, хэрэглэл, холбооны хэрэгслээр хангахыг дуудлага зохицуулж байгаа байгууллага хариуцна.
- 2.20 Алсын дуудлагын тээврийн хэрэгслийн хяналт, техникийн аюулгүй, бэлэн байдал, засвар үйлчилгээ, автопаркийн ашиглалттай холбоотой асуудлыг дуудлага зохицуулж байгаа байгууллага хариуцна.

#### **Гурав. Алсын дуудлага дуудах байгууллагын чиг үүрэг**

- 3.1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг нь эмч нарын хамтарсан зөвлөгөөн хийж, алсын дуудлага дуудах шаардлагатай үйлчилүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгч, төрөлжсөн мэргэжлийн тусlamжийн алсын дуудлага дуудах шийдвэр гаргана.
- 3.2. Алсын дуудлага дуудах эмгэгийн оношийн жагсаалтад заасан өвчиний оношоор (тус журмын 1 дүгээр хавсралт) алсын яаралтай тусlamжийн дуудлагыг аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс уг тушаалын 2 дугаар хавсралтанд заасан төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд телефон утас, факс, и-мэйлээр илгээнэ.
- 3.3. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга алсын дуудлагыг өгнө.
- 3.4. Алсын дуудлага дуудах өвчин, эмгэгийн жагсаалтад ороогүй бөгөөд тухайн эмнэлэгт үзүүлэх боломжтой тусlamж үйлчилгээнд болон өвчтөний ар гэрийн шахалтын дор алсын түргэн тусlamж дуудахыг хориглоно.
- 3.5. Алсын түргэн тусlamжийн дуудлагаар очсон эмч, мэргэжилтнийг үйлчилүүлэгчийн эмчлэгч эмч хүлээн авч мэдээллийг танилцуулах ба шаардлагатай тохиолдолд лаборатори, дурс оношлогооны эмч, эмийн санч зэрэг мэргэжилтнийг бэлэн байлгана.
- 3.6. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь эмнэлгийн яаралтай тусlamж үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлж, хэвийн ажиллагааг хангаж ажиллах ба мэс засал болон яаралтай тусlamж, эрчимт эмчилгээний тасагт камер байрлуулна.
- 3.7. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь эмч, мэргэжилтнийхээ мэргэжил, ур чадварыг тасралтгүй сайжруулж, гадаад, дотоодын сургалтад хамруулж, чадавхижуулах ажлыг зохион байгуулж ажиллана.
- 3.8. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв орон нутгийн засаг захиргаа, хууль сахиулах байгууллагатай хамтран осол, гэмтлээс сэргийлэх, бууруулахад чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлуудыг иргэдэд зохион байгуулах арга хэмжээг авч ажиллана.
- 3.9. Алсын түргэн тусlamжийн дуудлагаар очсон эмч, мэргэжилтний, аюулгүй байдал, амрах байр, халуун хоол, цай, тээврийн хэрэгслийг найдвартай дулаан гражаар хангаж ажиллахыг дуудлага дуудсан эрүүл мэндийн байгууллага хариуцна.
- 3.10. Ойрхон байршилтай 2 дуудлага зэрэг гарсан тохиолдолд дуудлага өгсөн хамгийн холын байршилтай эрүүл мэндийн байгууллага тээврийн хэрэгслийг угуулан гаргаж, товлосон газраас эмч, багийг авч, буцааж хүргэх үүрэг хүлээнэ.
- 3.11. Алсын дуудлаганд явах үед тээврийн хэрэгсэлд гэмтэл гарсан тохиолдолд хамгийн ойр орших эрүүл мэндийн байгууллагаас тээврийн хэрэгсэл ирүүлж, дуудлагын багийг авч, дуудлагын газарт хүргэх үүргийг хүлээнэ.

### **Дөрөв. Алсын дуудлаганд явах эмч, мэргэжлийн багийн чиг үүрэг**

- 4.1 Алсын дуудлаганд томилогдсон эмч, дуудлагын мэдээлэлтэй танилцаж, үйлчлүүлэгчийн эмчлэгч эмчтэй урьдчилан утас болон телемедицинээр холбогдох, зөвлөгөө өгөх, 2 цагийн дотор дуудлаганд явахад бэлэн болсон байна.
- 4.2 Алсын дуудлаганд явах эмч, баг нь шаардлагатай тохиолдолд эм тариа, багаж, тоног төхөөрөмжийг авч явна.
- 4.3 Алсын дуудлагаар очсон эмч, баг нь үйлчлүүлэгчид тусламж үзүүлж дууссаны дараа шаардлагатай өвчтөнд хамтарсан үзлэг хийж, зөвлөгөө өгнө.
- 4.4 Алсын дуудлагаас ирсний дараа дуудлагын хуудсыг бөглөж, тайлан бичиж, холбогдох материалын хамт ажлын З хоногт дуудлага зохицуулагч ажилтанд хулээлгэн өгнө.
- 4.5 Алсын дуудлагын эмч, мэргэжилтнүүдийн гэнэтийн ослын болон хариуцлагын даатгал, амь насны даатгалыг дуудлага зохицуулагч байгууллага хариуцаж даатгуулсан байна.
- 4.6 Алсын дуудлагын эмч, мэргэжилтнүүд нь ажил үүргээ гүйцэтгэх үедээ эзэмшигчийн нэр, албан тушаал, яаралтай тусламжийн таних тэмдэг бүхий ажлын тусгай хувцас /цамц, хүрэм/ өмсөнө.
- 4.7 Алсын дуудлагаар очиж тусламж үзүүлж буй эмч нар үйлчлүүлэгчдээс албан бус төлбөр /цус тогтоох губка, янз бүрийн зориулалтын гуурс гэх мэт/ авахыг хориглоно.

### **Тав. Алсын дуудлагын жолоочийн чиг үүрэг**

- 5.1 Алсын дуудлагын жолооч нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил тасралтгүй адил төстэй байгууллагад ажилласан, орон нутгийн газар зүй, замын байрлалын мэдлэг, дадлага, туршлагатай, амилуулах суурь тусламжийн сургалтад хамрагдсан, зам тээврийн осол, зөрчил гаргаж байгаагүй үндсэн жолооч байна.
- 5.2 Жолооч нь алсын түргэн тусламжийн дуудлаганд гарахаас өмнө тээврийн хэрэгсэлд техникийн үзлэг хийж, алсын дуудлагын бэлэн байдлын хяналтын хуудасны (тус журмын 2 дугаар хавсралт) заалт бүрийг үнэн зөв, бүрэн бөглөж, техникийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 5.3 Жолооч нь алсын түргэн тусламжийн дуудлагын эмч, багийг орон нутагт болон нисэх онгоц, галт тэрэгний буудалд хүргэж өгөх, тосч авах үүргийг хүлээнэ.
- 5.4 Жолооч нь эрүүл мэндийн үзлэгт орж, алсын дуудлагын бэлэн байдлын хяналтын хуудсаар шаардлага хангасан тохиолдолд дуудлаганд явна.
- 5.5 Жолооч нь орон нутагт очих болон буцах тухайгаа дуудлага зохицуулагч ажилтанд утсаар мэдэгдэнэ.
- 5.6 Жолооч нь ээлжээс буухдаа тээврийн хэрэгсэлд үзлэг хийж, гражид байрлуулан, спидометрийн заалт, шатахууны үлдэгдлийг ажлын дэвтэрт тэмдэглэн, дуудлага зохицуулагчид хүлээлгэн өгнө.
- 5.7 Жолооч нь алсын дуудлагын эмч, багийг ажлын цагаар бол байгууллага дээрээс нь, бусад үед байгаа байршилаас нь очиж авах үүрэг хүлээнэ.
- 5.8 Алсын дуудлагын тээврийн хэрэгсэлд үйлчлүүлэгчийн асран хамгаалагч, дуудлагын багийн гишүүдээс бусад зорчигч авч явахыг хориглоно.

**Зургаа. Санхүүжилт**

- 7
- 6.1 Алсын дуудлага гүйцэтгэсэн эмч, мэргэжилтний томилот, алсын дуудлагын тээврийн хэрэгслийн шатахуун болон онгоц, галт тэрэгний зардлыг дуудлагыг гүйцэтгэх эрүүл мэндийн байгууллага хариуцна.
  - 6.2 Засгийн газрын 2012 оны “Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл хөлс олгох тухай” 151 дүгээр тогтоолын дагуу дуудлагаар явсан эрүүл мэндийн ажилтанд тохиолдол бүрд нэмэгдэл хөлсийг олгоно.

#### **Долоо. Хариуцлага**

- 7.1 Хуваарьт алсын дуудлаганд яваагүй, цаг хугацаа оройтуулсан тохиолдолд тухайн эмч, мэргэжилтэнд байгууллагын дотоод журам, холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлагын асуудлыг шийдвэрлэнэ.
- 7.2 Эрүүл мэндийн үзлэг хийлгүй, алсын дуудлагын бэлэн байдлын хяналтын хуудсыг бөглөлгүйгээр жолоочийг дуудлаганд гаргаж, үүний улмаас хохирол үүссэн бол дуудлага зохицуулагч ажилтан хариуцлага хүлээнэ.

8

**АЛСЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГА ДУУДАХ  
ӨВЧИН, ЭМГЭГИЙН ЖАГСААЛТ**

№	Мэргэжлийн чиглэл, нэршил	Тусlamж авах хэлбэр		
		Газар	Телемедицин, дээр нь очих	
<b>Улсын нэгдүгээр төв эмнэлэг</b>				
<b>Нэг. Ерөнхий мэс заслын өвчин</b>				
1	Хэвллийн болон цээжний хөндийн хагалгааны дараах хүндрэл.	+	+	
2	Уушгинаас зогсолтгүй цус алдах	+	+	
3	Хоол боловсруулах замын эрхтний үргэлжилсэн цус алдалтыг зогсоох	+	+	
4	Хэвллийн болон цээжний эрхтний буглаа, бэтэг түүний хүндрэл	+	+	
<b>Хоёр. Беөр шээсний замын өвчин</b>				
5	Беөр, шээсний замын эрхтний гэмтэл	+	+	
6	Мэс заслын дараах хүндрэл	+	+	
7	Беөр, шээсний замын цус алдалт	+	+	
8	Бэлэг эрхтний хүнд хэлбэрийн гэмтэл	+	+	
<b>Гурав. Чих, хамар хоолойн өвчин</b>				
9	Хурц цус алдалт	+	+	
10	Тээвэрлэх боломжгүй чих хамар дайврын үрэвслийн гаралтай гавал тархины хүндрэл	+	+	
<b>Дөрөв. Нүдний өвчин</b>				
11	Нүдний нэвтэрсэн хүнд гэмтэл	+	+	
12	Нүдний ухархайн хүнд гэмтэл	+	+	
<b>Гэмтэл, согог судлалын үндэсний төв</b>				
<b>Тав. Гэмтэл, осол</b>				
13	Галт болон хүйтэн зэвсгийн хүнд хэлбэрийн шарх, цус алдалт	+	+	
14	Цээж хэвллийн хөндийн эрхтэн болон хавсарсан хүнд гэмтэл	+	+	
15	Гавал тархи, нуруу нугасны тээвэрлэх боломжгүй шинэ гэмтэл	+	+	
<b>Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв</b>				
<b>Зургаа. Эх барих, эмэгтэйчүүдийн өвчин</b>				
16	Эх барих, эмэгтэйчүүдийн хагалгааны дараах хүндрэл	+	+	
17	Эх барихын цочмог цус алдалт, дайрлаганд орсон	+	+	

	/Алдсан цусны хэмжээ 3000мл-ээс дээш /		
18	Цус түгээмлээр бүлэгнэх хам шинжийн шалтгаант цус алдалт	+	+
19	Ихэс шигдсэн-ихэс түрүүлсэн тохиолдолд давсаг руу шигдэлт үүссэн цус алдалттай үед / Урологийн эмч хамт дуудах/	+	+
20	Давшиングуй явцтай HELLP хам шинж	+	+
21	Манас таталтын хүндрэл	+	+
22	Ээнэгшил алдагдсан зурхний эмгэг	+	+
23	Хэвлийн томорсон жирэмсэн, тээвэрлэх боломжгүй тохиолдол	+	+
24	Эрхтэн тогтолцооны хавсарсан эмгэгтэй жирэмсэн	+	+
<b>Долоо. Хүүхэд, нярайн өвчин</b>			
25	Олон эрхтэний дутмагшил бүхий халдварт хордлогын хам шинж	+	+
26	Нярайн мэс заслын яаралтай эмгэгүүд	+	+
27	Мэс заслын эмгэгүүдийн хүндрэл-шок	+	+
28	Чинэрсэн гидронефроз	+	+
29	Нярайн хүнд хэлбэрийн амьсгал хямралын хамшинж, үжлийн хүнд шок, тархины цус харвалт, нярайн цус задрах өвчин	+	+
30	Төрөлхийн уруул, тагнайн нэг ба хоёр талын бүтэн сэтэрхийтэй, хөхөө хөхөх чадваргүй, хооллолтын бэрхшээлтэй тохиолдолд		+
31	Бөөрний цочмог, архаг дутагдал		+
32	Нефротик криз	+	+
33	Тиреотоксикозийн криз	+	+
34	Чих, хамрын гаралтай гавал тархины хүндрэл		+
35	Мэнэн, хүнд хэлбэрийн цус харвалт, энцефалит	+	+
36	Элэгний хатуурлын хүнд хэлбэр		+
37	Зүрхний төрөлхийн хавсарсан хөх хэлбэрийн гажгууд		+
38	Янз бүрийн шалтгаант хүнд хэлбэрийн амьсгалын дутал	+	+
39	Төвөнхийн хүнд бачуурал III, IV Гуурсан хоолойн багтраат өвчний статуст байдал	+	+
40	Төвийн гаралтай хөхрөлт	+	+
41	Зүрхний хэм хэт түргэсэлт		+
42	Цус эргүүлгийн хямралын II а-б, III	+	+
43	Бүх төрлийн цохиулалт-шок (орчих цус хомсдолын, цус алдалтын, усгүйжилтүүн, зүрхний шалтгаант, үжлийн, гаждал цохиулалтын)	+	+
44	Захын судсанд цус нилэнхүй бүлэгнэх хам шинж илэрсэн бүх тохиолдлууд	+	+
45	Бүх төрлийн оврого-кома (тархины дутмагшлын III, IV)	+	+
46	Чихрийн шижингийн оврого	+	+

47	Таталтын статуст хам шинж			+
48	Амь насанд аюултай артерийн даралт ихдэлт	+		+
49	Нойр булчирхайн хүнд хэлбэрийн цочмог үрэвсэл	+		+
50	Хүнд хэлбэрийн цочмог хордолт, золгүй тохиолдлууд,	+		+
51	Лейкоз, тромбоцитопеническая пурпуря, апластик анеми, гемофили			+

### Улсын гуравдугаар төв эмнэлэг

#### **Найм. Зүрх, судасны өвчин**

52	Тараагуур болон хураагуур судасны цочмог бөглөрөл	+	+
53	Том судаснаас цус алдсан тохиолдол, судас залгах	+	+
54	Зүрхний хавхлага суулгах, хиймэл судас тавиулсны дараах бүлэнт хүндрэл	+	+
55	Зүрхний төрөлхийн гурвалсан, дөрвөлсөн хөх гажгийн хүндрэл	+	+

#### **Җс. Мэдрэлийн өвчин**

56	Мэс заслын заалт бүхий тархины судасны цочмог хямрал	+	+
57	Тархи нугасны дарагдалтыг чөлөөлөх	+	+

### Халдварт өвчин судлалын үндэсний төв

#### **Арав. Халдварт өвчин**

58	Уушгинь хөндийт сүрьеэгийн цус алдалт	+	+
----	---------------------------------------	---	---

### Хавдар судлалын үндэсний төв

#### **Арван нэг. Хавдар**

59	Элэгний задарч буй хавдарт ангиографийн ажилбар хийх	+	+
60	Нойр булчирхай, цөсний замын хавдрын бөглөрөлтийн шалтгаант шарлалт, түгжрэлийн үед хийх хөнгөвчлөх мэс засал	+	+
61	Хими эмчилгээний дараахи хүндрэл, хордлого		+
62	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний зөвлөлгөө		+

#### **Арван хоёр. Бусад**

63	Амьсгалын цочмог дутмагшил		+
64	Тархины цусны эргэлтийн цочмог хямрал, цус харвалт		+
65	Тархины цочмог дутмагшил /ком/		+
66	Олон эрхтний дутмагшил		+
67	Бөөрний дээд булчирхайн цочмог дутмагшил		+
68	Элэгний цочмог дутмагшил		+
69	Бөөрний цочмог дутмагшил		+
70	Зүрх гэнэт зогсох		+
71	Зүрхний цочмог дутмагшил		+
72	Цочмог хордолт, хордлогошил		+
73	Амь насанд аюултай гэмтэл, мэс заслын цочмог эмгэгүүд		+
74	Толгойн гэмтэл		+

75	Цочмог панкреатит		+
76	Цочмог хэвлийн өвдөлт		+
77	Улаан хоолойн хураагуур судасны өргөсөлт		+
78	Манас таталтын урьдал, манас таталт		+
79	Зүрхний хэм алдалтын хүнд хэлбэр		+
80	Халдвэр хордлогын хамшинж		+
81	Удаан хугацаагаар дарагдах хам шинж		+
82	Таталттай халууралт		+
83	Хий юм харах, дэмийрэл бүхий солиорол, хурц догшрол		+
84	Дайрлага /шок/		+
85	Лайеллийн хамшинж	+	

## АЛСЫН ДУУДЛАГЫН БЭЛЭН БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

Жолоочийн овог нэр: .....

Тээврийн хэрэгслийн дугаар: .....

## Жолоочийн эрүүл мэндийн үзлэг

№	Үзлэгийн төрөл	Шаардлага			Тайлбар
			Тийм	Үгүй	
<b>Нэг. Ерөнхий үзлэг.</b>					
1	Цусны даралт	цусны даралт хэвийн (даралтыг 2 гарг 3 удаа үзэж тэмдэглэх)			
2	Зүрх судасны систем	Хэвийн			
3	Амьсгалын систем	Хэвийн			
4	Яс булчингийн тогтолцоо	Хэвийн			
5	Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх	үгүй			

Эрүүл мэндээр тэнцэнэ, тэнцэхгүй /зур/  
..... /жолооч/

Зөвшөөрсөн:

Дуудлага зохицуулагч ажилтан: ..... /  
/

/гарын үсэг/ /овог

нэр/

Огноо, цаг минут: .....

## Автомашины үзлэг

№	Шалгах эд анги	Шалгуур	Шалгуур хангасан		Тайлбар
			Тийм	Үгүй	
<b>Нэг. Цахилгаан, гэрэл дохио</b>					
1	Их гэрэл	асах			
2	Ойрын гэрэл	асах			
3	Оворын гэрэл	асах			
4	Дохио, аваарын гэрэл	Асах, анивчих			
5	Акумляторийн цэнэг	12 вольт			
6	Цахилгааны холбогч	байгаа			
7	Автомашины дуут дохио	дуугарах			
8	Тусгай гэрэл, дуут дохио	Асах, дуугарах			

11	Ослын гэрэлт пуужин	Зш			
12	Зөөврийн гэрэл	1ш			
<b>Хоёр. Мотор, тос, түлш</b>					
13	Моторын тосны түвшинг шалгах	Дээд доод түвшний дунд			
14	Залах хурдний шингэн шалгах /руль/	Дээд доод түвшний дунд			
15	Тормосны систем шалгах /шингэн, хоолой, накладка/	Дээд доод түвшний дунд			
16	Моторын хөргөлтийн шингэний түвшинг шалгах	Таглаагаар харагдах			
17	Хурдны хайрцагны тосны түвшин	Дээд доод түвшний дунд			
18	Моторын асалт	сайн			
19	Түлшний сав	гоожоогүй			
20	Нөөц түлшний сав	Гоожихгүй, таг сайн			
21	Нөөц түлш /бензин/	20л			
22	Дулаан үлээгч	ажилладаг			
<b>Гурав. Дугуй, зогсоох систем</b>					
23	Дугуйны хийн даралт	Урд 2,7 кг/см <sup>2</sup>			
24		Хойд 2,7 кг/см <sup>2</sup>			
25	Нөөц дугуй	2ш			
26	Нөөц олгой хамер	2ш			
27	Дугуйн хээний хэмжээ	0,8 см-ээс дээш			
28	Тормос сайн	4 дугуй зэрэг			
29	Гар тормос	ажилладаг			
30	Автомат дугуй хийлэгч	1ш			
31	Дугуйн нөхөөс	1 ком			
32	Дугуйны ивүүр төмөр	2 ш			
<b>Дөрөв. Эмнэлгийн тусlamжийн хэрэгслэл</b>					
33	Жолоочийн эмнэлгийн анхан шатны тусlamжийн иж бүрдэл	1ш			
34	Угсардаг наасилк	1ш			
35	Чиг баригч	Хөлний -3ш			
		Гарны-3ш			
		Хүзүүний-3ш			
		Нурууны-3ш			

36	Ариутгасан ороох боох материал	5 ком				
<b>Тав. Багаж, бусад хэрэгслэл</b>						
37	Түлхүүр , багаж	Хангалттай				
38	Галын хор	1ш				
39	Ослын зогсолтын гурвалжин тэмдэг	1ш				
40	Зөөлөн татлага, чирэгч трос	1ш				
41	Байршил тогтоогч GPS Аяллын цахим хөтөч	1ш				
42	Дулаан хувцас (өвлийн улиралд дах дэгтий, машины бүтээлэг)	1ш				
43	Тахлын хувцас	3ш				
44	Ариутгалын бодис	2 л				
45	Зөөврийн, тулш бензинээр ажилладаг дулаан үүсгүүр	1ш				
46	Майхан, аяны хөнжил	1 ш				
47	Гэрэлтүүлэгч	1ш				
48	Замын хүнс	2 хүн, 2 өдрийн				
49	Холбооны утас /шаардлагатай тохиолдолд/	1 ш				
50	Зургийн аппарат /шаардлагатай тохиолдолд/	1ш				
51	Газын плитка /нөөц газтай/ /шаардлагатай тохиолдолд/	1ш				

Автомашины техникийн үзүүлэлт тэнцэнэ, тэнцэхгүй /зур/

Аж ахуй хариуцсан менежер : ..... /

/гарын үсэг/

/овог нэр/

Огноо, цаг минут: .....

Эрүүл мэндийн сайдын 2014 оны  
08. сарын 11. өдрийн дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

### АЛСЫН ДУУДЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ХУВААРЬ

№	Чиг үүрэг	Гүйцэтгэх байгууллага	Тусlamж үйлчилгээг үзүүлэх хэлбэр
1	Мэс заслын тусlamж, үйлчилгээ	УНТЭ	<ul style="list-style-type: none"> <li>Дуудлага зохицуулалт</li> <li>Яаралтай тусlamж үйлчилгээг газар дээр нь очиж үзүүлэх</li> <li>Зөвлөгөө өгөх</li> <li>Алсын зайн оношилгоо, эмчилгээ</li> </ul>
2	Зүрх судас, тархи, нуруу нугасны өвчлөл, мэдрэлийн тусlamж үйлчилгээ	УГТЭ	<ul style="list-style-type: none"> <li>Дуудлага зохицуулалт</li> <li>Яаралтай тусlamж үйлчилгээг газар дээр нь очиж үзүүлэх</li> <li>Зөвлөгөө өгөх</li> <li>Алсын зайн оношилгоо, эмчилгээ</li> </ul>
3	Эх, хүүхдийн тусlamж үйлчилгээ	ЭХЭМҮТ	<ul style="list-style-type: none"> <li>Дуудлага зохицуулалт</li> <li>Яаралтай тусlamж үйлчилгээг газар дээр нь очиж үзүүлэх</li> <li>Зөвлөгөө өгөх</li> <li>Алсын зайн оношилгоо, эмчилгээ</li> </ul>
4	Гэмтэл, ослын тусlamж үйлчилгээ	ГССҮТ	<ul style="list-style-type: none"> <li>Дуудлага зохицуулалт</li> <li>Яаралтай тусlamж үйлчилгээг газар дээр нь очиж үзүүлэх</li> <li>Зөвлөгөө өгөх</li> </ul>
5	Бусад	УНТЭ УГТЭ ЭХЭМҮТ ГССҮТ	<ul style="list-style-type: none"> <li>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, ХЯТТөв болон бусад мэргэжлийн байгууллагатай зөвшилцөн, зохицуулах, удирдан, зохион байгуулах</li> <li>Төрөлжсөн мэргэжлийн хамтарсан багийг (эх барих, тархи, зүрхний баг г.м) шуурхай зохион байгуулж явуулах</li> </ul>

Эрүүл мэндийн сайдын 2014 оны  
08... сарын..... өдрийн 25 дугаар  
тушаалын 3 дугаар хавсралт

**ЯВУУЛЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ  
ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВААРЬ**

№	Чиг үүрэг	Гүйцэтгэх байгууллага	Тусlamж үйлчилгээг үзүүлэх хэлбэр
1	Мэс ажилбар хийх боломж бүхий ерөнхий эмчилгээний явуулын эмнэлэг	ҮГТЭ	газар дээр нь очиж үзүүлэх мэс заслын болон ерөнхий мэргэжлийн тусlamж, үйлчилгээ
2	Дижитал рентген аппарат бүхий иж бүрэн шүдний явуулын эмнэлэг	Дархан - Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	газар дээр нь очиж үзүүлэх шүд (нүүр ам судлал)-ын тусlamж, үйлчилгээ
3	Бүрэн дижитачлагдсан тоног, төхөөрөмж бзхий иж бүрэн рентгений явуулын эмнэлэг	ХӨСҮТ	газар дээр нь очиж үзүүлэх рентген оношлогоо, үйлчилгээ

Жич: Дээрх явуулын эмнэлгүүдийг нийтийг хамарсан осол, онцгой байдлын үед төв, орон нутгийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд дайчлан ажиллуулж болно.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны  
08. сарын 11. өдрийн 263 дугаар  
тушаалын 4 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВӨӨС ШИЛЖИХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Шилжих хөрөнгө	Төсөв /төгрөгөөр/
1	Тээврийн хэрэгсэл	267 830.450
2	Тоног төхөөрөмж, эд хогшил	2 949 899
3	Нүүдлийн 3 эмнэлэг	1 570 000 000
	Мэс ажилбар хийх боломж бүхий ерөнхий эмчилгээний эмнэлэг	380 000 000
	Дижитал рентген аппарат бүхий иж бүрэн шүдний эмнэлэг	390 000 000
	Бүрэн дижитачлагдсан тоног төхөөрөмж бүхий иж бүрэн рентген эмнэлэг	800 000 000
4	Нийт зардал	1 840 780 349